



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/59

Дархан

Захиргааны актыг хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, 48.2.1 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.9 дахь заалт, 6.3 дахь хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.1 дэх заалт, Засгийн газрын 191 дүгээр тогтоолоор батлагдсан "Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам"-ын 5.2.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтад заасан Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас метрийн дотор тамхи худалдах гэсэн шаардлага хангаагүй тул хавсралтад заасан Аж ахуйн нэгжийн тамхи худалдан борлуулах энгийн зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, арга хэмжээ авч ажиллахыг Багийн засаг дарга, хэсгийн байцаагч нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан захирамж 2024 оны А/59 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Т.ТУЛГАА

4525010176

D.ajil.Zahiramj-2025

Дархан сумын Засаг даргын 2025 оны
...⁰³ дүгээр сарын ...¹² ний өдрийн
...^{А/59} дугаар захимрамжийн хавсралт



Захиргааны актыг хүчингүй болгох аж ахуй нэгж байгууллагын нэр

№	Баг	Аж ахуйн нэгж байгууллага	Үйл ажиллагааны чиглэл
1	5 дугаар баг	Хан Хөхий Ган ХХК	Гялс супермаркет
2	5 дугаар баг	Хүслэн Золбоот ХХК	Бөөний төв

_____ооо_____